



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/157

Зуунмод

Хорио цээрийн дэглэмийг сунгах тухай

Зуунмод суманд Коронавируст /Ковид-19/ цар тахал бүртгэгдэж өнөөдрийн байдлаар батлагдсан тохиолдол 16-д хүрээд байна. Коронавируст халдварын тархалтын цар хүрээг тогтоох, голомтыг илрүүлэх зорилгоор “Нэг өрх-Нэг шинжилгээ” арга хэмжээг 03 сарын 8, 9-ны өдрүүдэд зохион байгуулж Зуунмод сумын 6 багийн 4912 өрхөөс 4489 өрхийн өрх тус бүрийн нийгмийн харилцаанд идэвхтэй оролцдог 1 гишүүн шинжилгээнд хамрагдлаа.

Батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болох 120 иргэн ажиглан тусгаарлах 8 байранд хяналтад, Зуунмод, Бүрэн, Эрдэнэсант, Баянчандмань, Жаргалант, Алтанбулаг, Эрдэнэ, Борнуур, Угтаалцайдам суманд 479 иргэн гэрийн ажиглалтад байгааг тэмдэглээд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, 4 дүгээр зүйлийн 4.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд коронавируст халдварын 16 тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Зуунмод суманд хөл хорионы дэглэмийг 2021 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 20:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. Хөл хорионы дэглэм сунгасантай холбогдуулан аймгийн Онцгой комисс, Зуунмод сумын Онцгой комисс, аймгийн Шуурхай штаб, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага (Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар), онц чухал стратегийн зориулалттай байгууллага харилцаа холбоо, усан хангамж, дулаан, цахилгаан түгээх компаниудаас бусад бүх байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүрэн зогсоож, зорчих хөдөлгөөнийг хязгаарласугай.

3. Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлж, хөл хорионы үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг хэлтэс, агентлаг, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Хөл хорионы дэглэмийн үед ариутгал халдваргүйтгэлийг зохион байгуулж, хүнсний худалдаа, эмийн сангийн үйл ажиллагааг тусгай нөхцөл, шаардлага зөвлөмжийн дагуу үе шаттай нээж ажиллуулахыг Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл)-д даалгасугай.

5. Зуунмод сумын доторх болон орох иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж гарах хөдөлгөөнийг нээж гарсан иргэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл эргэн орохгүй байлгах арга хэмжээ авч бусад аймаг орон нутагт дамжин өнгөрч

байгаа иргэдийг нотлох баримтыг үндэслэн хөдөлгөөн үйлдүүлж, хяналт тавьж зорчуулахыг Цагдаагийн газар (Б.Ганзориг), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт даалгасугай.

6. Халдвар илэрсэн иргэдийн ойрын болон дам хавьтлыг тогтоож тусгаарлах арга хэмжээг авах, ажиглан тусгаарлах байруудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-г нарт үүрэг болгосугай.

7. Зуунмод суманд коронавируст халдвар илэрсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, эргүүл жижүүр тогтмолжуулан хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 06-ны өдрийн А/146 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч, дарга бөгөөд Онцгой байдлын газрын дарга (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР